



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Мандал хишиг хайрхан” ОНӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2022/14-НА-СТА-ОНА

<p>Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn</p> <p>Сүхбаатар сум 2022 он</p>	<p>Тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 7036-3040 Цахим хаяг: Enkhtuyach@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 7036-3036 Цахим хаяг: Batmunkhb@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор: Т.Болор Утас: 7036-2442 Цахим хаяг: bolort@audit.gov.com</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

СЭА-2022/14-НА-СТА-ОНА

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт.....	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан.....	5
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан.....	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.5 Техник, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл	7
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	8
3.1 Байгууллагын үйл ажиллагаа.....	8
3.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин.....	8
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого.....	9
3.4 Зорилтот түвшний гүйцэтгэл.....	9
4. Аудитын тайлан.....	10
4.1 Ерөнхий зүйл.....	10
4.2 Дотод хяналт.....	10
4.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	10
4.4 Материаллаг байдал.....	10
5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	11
5.1 Шилэн дансны мэдээлэл.....	11
5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд	10
6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	12
7. Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	12
8. Аудитын илрүүлэлт	13
8.1 Зөвлөмж	13
9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	14

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум
Цагаан Эрэг II байр
Утас: 7036-3040, Факс: (976)-7036-3040
E-mail: Selenge@audit.gov.mn

**“МАНДАЛ ХИШИГ ХАЙРХАН”
ОНӨААТҮГ-ЫН ДАРГА
Б.БАТҮҮЛ ТАНАА**

2022.03.15 № СЭА-2022/14-НА-СТА-ОНА

танай _____-ны № _____-г

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Мандал хишиг хайрхан” ОНӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

“Мандал хишиг хайрхан” ОНӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. *Бусад мэдээлэл нь (Байгууллагын жилийн тайланд орсон, санхүүгийн тайлан ба аудиторын тайлангаас бусад мэдээлэл) санхүүгийн ба санхүүгийн бус мэдээллийг агуулсан байна.*

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

Аудит
Хийсэн
Тайлан
/Төгрөгөөр/
2022.05.05

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	36,706.45	-
1.1.6	Бараа материал	2,171,034.14	2,171,034.14
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	2,207,740.59	2,171,034.14
1.2.1	Үндсэн хөрөнгө	271,360,052.43	260,687,850.78
1.2.2	Биет бус хөрөнгө	102,362,666.60	102,162,666.60
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	373,722,719.03	362,850,517.38
1.3	Нийт хөрөнгийн дүн	375,930,459.62	365,021,551.52
2.1.1.1	Дансны өглөг	8,633,350.00	8,633,350.00
2.1.1.2	Цалингийн өглөг	6,231,509.91	6,231,509.91
2.1.1.3	Татварын өр	5,737,414.17	5,737,414.17
2.1.1.4	НДШ-ийн өглөг	15,676,967.34	16,712,267.34
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	36,279,241.42	37,314,541.42
2.1.2.1	Урт хугацаат зээл	11,304,800.00	11,304,800.00
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	11,304,800.00	11,304,800.00
2.2	Өр төлбөрийн нийт дүн	47,584,041.42	48,619,341.42
2.3.1	Өмч: -Төрийн	276,183,000.00	276,183,000.00
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	15,467,638.88	15,467,638.88
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	101,696,000.00	101,696,000.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(65,000,220.68)	(76,944,428.78)
2.3.11	Эздийн өмчийн дүн	328,346,418.20	316,402,210.10
2.4	Өр төлбөр ба эздийн өмчийн дүн	375,930,459.62	365,021,551.52

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	Борлуулалтын орлого (цэвэр)	20,382,393.51	-
2	Борлуулалтын өртөг	34,662,203.15	11,907,501.65
3	Нийт ашиг (алдагдал)	(14,279,809.64)	(11,907,501.65)
10	Ерөнхий ба удирдлагын зардал	7,875,632.19	36,706.45
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(22,155,441.83)	(11,944,208.10)
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(22,155,441.83)	(11,944,208.10)
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(22,155,441.83)	(11,944,208.10)
24	Орлогын нийт дүн	(22,155,441.83)	(11,944,208.10)

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
8	2020 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	276,183,000.00	15,467,638.88	101,696,000.00	(65,000,220.68)	328,346,418.20
1	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-	-
2	Залруулсан үлдэгдэл	276,183,000.00	15,467,638.88	101,696,000.00	(65,000,220.68)	328,346,418.20
3	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	(11,944,208.10)	(11,944,208.10)
4	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	-
5	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-	-
6	Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-
7	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	-	-
8	2021 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	276,183,000.00	15,467,638.88	101,696,000.00	(76,944,428.78)	316,402,210.10

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1.1	Мөнгөн орлогын дүн	22,481,250.00	-
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	22,481,250.00	-
1.1.6	Бусад мөнгөн орлого	-	-
1.2	Мөнгөн зарлагын дүн	22,689,193.73	36,706.45
1.2.1	Ажиллагчдад төлсөн	8,533,765.13	-
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	4,530,360.00	-
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	7,915,668.10	-

"Мандал хишиг хайрхан" ОНӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн
тайлангийн аудитын тайлан

1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	1,500,000.00	
1.2.9	Бусад мөнгөн зарлага	209,400.50	36,706.45
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(207,943.73)	(36,706.45)
4.1	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(207,943.73)	(36,706.45)
5	МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	244,650.18	36,706.45
6	МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ	36,706.45	-

2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2020 оны гүйцэтгэл	2021 оны		Зөрүү	Хувь
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Тээрмийн орлого		13,420,600.00	46,850,000.00	-	-	-
2	Түрээсийн орлого		9,000,000.00	21,600,000.00	-	-	-
3	Шлам борлуулсны орлого		-	15,000,000.00	-	-	-
	Нийт орлого		22,420,600.00	83,450,000.00	-	-	-
1	Үүнээс: Цэвэр борлуулалт		20,382,393.51	83,450,000.00	-	-	-
	Нийт зардал		42,537,835.34	81,810,432.04	-	-	-
1	Үүнээс: Борлуулсан бүтээгдэхүүний өртөг		34,662,203.15	54,281,953.00	-	-	-
2	Ерөнхий ба удирдлагын зардал		7,875,632.19	27,528,479.04	-	-	-
3	Хөрөнгө оруулалт их засварын зардал		-	-	-	-	-
	Цэвэр ашиг, алдагдал		(22,155,441.83)	1,639,567.96	-	-	-

3. Санхүүгийн тайлангийн тодруулга

3.1 Байгууллагын үйл ажиллагаа

“Мандал хишиг хайрхан” ОНӨААТҮГ-ын дүрэмд тус байгууллагын үндсэн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Гадаад худалдаа,
- Зочид буудал, зоогийн газрын үйлчилгээ,
- Хүдэр боловсруулах, эрхлэх үйл ажиллагаа гэх мэт

3.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

“Мандал хишиг хайрхан” ОНӨААТҮГ-ыг сумын ИТХ-ын 2018 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн 48 дугаар тогтоолыг үндэслэн байгуулсан байна.

Энэ нь Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлд “Сум, дүүргийн Хурлын бүрэн эрх”, 18 дугаар зүйлийн 18.1.3-ын ж-д “Орон нутгийн өмчит хуулийн этгээд байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэр гаргах, **дүрмийг батлах**”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2-д “Орон нутгийн өмчийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах талаар иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дараах бүрэн эрхтэй ... 4/ **орон нутгийн өмчийн хуулийн этгээд байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэр гаргаж, гүйцэтгэлд нь хяналт тавих**” гэсэн заалттай нийцэж байна.

Мандал сумын ЗДТГ-аас олгосон эд хөрөнгийн үндсэн дээр өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар ажиллах, сумын бичил уурхай эрхлэгчдийн олборлосон баяжмалыг боловсруулж, эцсийн бүтээгдэхүүн болгох, хүдэр баяжуулах цехээс гарсан хаягдал шламыг иргэдэд буцаан олгохгүй, иргэдийн эрүүл аюулгүй байдлыг ханган, байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэхгүй ажиллахаар дүрэмд заасан байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

• УИХ-аас 2021 оны 6 дугаар сард Нийгмийн даатгалын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан даатгуулагчийн сард төлбөл зохих нийгмийн даатгалын шимтгэлийн доод хэмжээ нь Засгийн газраас баталсан тухайн үед мөрдөж байгаа хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тэтгэврийн даатгалд 11.5 хувиас, тэтгэмжийн болон үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалд тус бүр 1.0 хувиас багагүй байна гэж өөрчлөлт оруулсан,

• Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

“Мандал хишиг хайрхан” ОНӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлан нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
А	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	36.70	-	(36.70)
Бараа материал	2,171.00	2,171.00	-
Үндсэн хөрөнгө	373,722.70	362,850.50	(10,872.20)
Нийт хөрөнгө	375,930.40	365,021.50	(10,908.90)
Өр төлбөр	47,584.00	48,619.30	1,035.30
Эздийн өмч	328,346.40	316,402.20	(11,944.20)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	375,930.40	365,021.50	(10,908.90)

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 362,850.5 мянган төгрөг болж, 10,872.2 мянган төгрөгөөр буурсан нь тайлант хугацааны үндсэн хөрөнгийн элэгдэлтэй холбоотой байна.

Өр төлбөрийн дансны үлдэгдэл 48,619.3 мянган төгрөг болж, 1,035.3 мянган төгрөгөөр өссөн нь Ковид-19 цар тахалтай холбоотойгоор ажилчдыг чөлөөлөх боломжгүй байснаас НДШ-ийн өглөг 1,035.3 мянган төгрөгөөр нэмэгдсэнээс шалтгаалсан байна.

Эздийн өмч дансны үлдэгдэл 316,402.2 мянган төгрөг болж, 11,944.2 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн алдагдал 11,944.2 мянган төгрөг болсноос шалтгаалжээ.

3.4. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу “Мандал хишиг хайрхан” ОНӨААТҮГ нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Тус газар нь 2021 оны үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөөг боловсруулж, Мандал сумын ИТХ-ын 2021 оны 14 дүгээр тогтоолоор баталсан байна.

Тус газрын орлого нь сумын бичил уурхай эрхлэгч нөхөрлөл, иргэдийн бэлтгэсэн алтны чулууны хүдрийг тээрэмдэж, боловсруулсны үйлчилгээний хөлснөөс голчлон бүрддэг бөгөөд тайлант хугацаанд Ковид-19 цар тахлын хөл хорионы улмаас нөхөрлөл, иргэд алт олборлоогүйгээс шалтгаалан үйл ажиллагаа явуулаагүй байна.

4. Аудитын тайлан

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу “Мандал хишиг хайрхан” орон нутгийн өмчийн аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар /цаашид “Мандал хишиг хайрхан” ОНӨААТҮГ гэх/-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Т.Болор гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

“Мандал хишиг хайрхан” ОНӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайланг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 03 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Дотоод хяналт

“Мандал хишиг хайрхан” ОНӨААТҮГ нь дотоод аудитын нэгж, хариуцсан ажилтангүй бөгөөд тайлант онд үйл ажиллагаа явуулаагүйтэй холбоотойгоор хяналт, шалгалт хийгдээгүй байна.

4.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

“Мандал хишиг хайрхан” ОНӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

4.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр тайлант оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн борлуулалтын орлогыг сонгож, материаллаг буруу

илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн борлуулалтын орлогын 20,437.5 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 204.4 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн болно.

5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

5.1 Шилэн дансны мэдээлэл


Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

“Мандал хишиг хайрхан” ОНӨААТҮГ нь 2021 онд үйл ажиллагаа явуулаагүйтэй холбоотойгоор шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс 51 мэдээллийг хугацаанд нь, 98 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Шийдвэрлэсэн нь: Хэдийгээр тайлант онд үйл ажиллагаа явуулаагүй ч гэсэн Шилэн дансны тухай хууль, журмын хэрэгжилтийг ханган, шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг тогтоосон хугацаанд байршуулж байх.

5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Засгийн газрын 2021 оны 43 дугаар “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” тогтоолын 1.3-д “Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх” гэж заасны дагуу шагнал урамшуулал олгоогүй, зочин төлөөлөгч хүлээн авах болон бэлэг дурсгалын зардал гаргаагүй байна.



6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн 2 зөрчилд албан шаардлага өгсөн байна.

Хүснэгт 2. Албан шаардлагын хэрэгжилт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Гүйцэтгэлийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Албан шаардлага	2	-	-	-	-
Нийт дүн	2	-	-	-	-

Тус газар нь Ковид-19 цар тахлын хөл хорионы улмаас тайлант хугацаанд үйл ажиллагаа явуулаагүй учир албан шаардлагын зөвлөмж тооцох боломжгүй байна.

7. Дараагийн аудитаар анхаарах асуудал

7.1 Ковид-19 цар тахлаас шалтгаалан иргэд хувиараа алт олборлох боломж нөхцөл бүрдээгүйгээс тус үйлдвэрийн газар нь 2021 онд үйл ажиллагаа явуулаагүй, үндсэн ажилтнууд нь ажиллаагүй хэдий ч ажлаас чөлөөлсөн шийдвэр гараагүйгээс сул зогсолтоор тооцон тухайн жилийн НДШ-ийг тооцож, өр үүсгэсэн бөгөөд үйл ажиллагаа явуулаагүй гэдэг шалтгаанаар шилэн дансны мэдээллийг тогтоосон хугацаанд нь мэдээлээгүй байна. Тайлант хугацаанд тус газрын эзэмшилд бүртгэлтэй үндсэн хөрөнгөд элэгдэл тооцож, бүртгэсэн байна.

7.2 Тус үйлдвэрийн газар нь тогтвортой үйл ажиллагаа явуулах боломжгүй, өөрөө өөрийгөө санхүүжүүлэн ажиллах чадваргүй гэж үзвэл татан буулгах шаардлагатай эсэх асуудлыг дараагийн аудитаар нарийвчлан авч үзэх нь зүйтэй юм.

8. Аудитын илрүүлэлт

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн асуудлаар 1 зөвлөмж өгсөн.

АДБОУС 4000.16-д заасны дагуу дээрх асуудал нь санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтэд нөлөөлөхгүй болно.

8.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Шилэн дансны мэдээлэлтэй холбоотой асуудал:

1.1 Илрүүлэлт: Шилэн дансны цахим хуудсанд мэдээлбэл зохих 149 мэдээллээс 98 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. / үйл ажиллагаа явуулаагүй гэдэг үндэслэлээр /

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4, 6.10 дахь заалтыг зөрчсөн ба санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангаагүй байна.

1.2 Өгсөн зөвлөмж: Шилэн дансны мэдээллийг тогтоосон хугацаанд нь мэдээлж байх.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

Д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс						Хариуцлага тооцох		Зөвлөмж		/мянган төгрөгөөр/		
				Тоо	Дүн	Загруулга		Акт		Албан шаардлага		Тоо	Дүн	Тоо	Дүн			
						Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн							
Санхүүгийн тайлангийн асуудлаар																		
1	"Мандаг хилиг хайрхан" ОНӨААТҮГ	СЭА-2022/14-НА-СТА-ОНА	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	
ДҮН																		
Санхүүгийн тайлангийн асуудлаар шалгасан нийцлийн асуудал																		
1	"Мандаг хилиг хайрхан" ОНӨААТҮГ	СЭА-2022/14-НА-СТА-ОНА	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
ДҮН																		
НИЙТ ДҮН																		
				-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-